



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.Umnugovii@audit.mn

Өмнөговь аймаг
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn
Аудитор С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
Аудитор Э.Жаргал
Утас: 70533552 Цахим хаяг: Jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

Нэг. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлт:



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.04.20 № 307

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Өмнөговь аймгийн засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өмнөговь аймгийн засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хог хаягдлын үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 186.0 сая төгрөгөөр биелүүлээгүй, Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 15.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, санхүүгийн тайлан баталгаажуулаагүй орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК-ний 31,588.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө нэгтгэгдсэн зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалтууд болон АДБОУС200, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон зүйл

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 515,144.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 375,044.9 сая төгрөг бүрдүүлж төсвийн орлого 27.2 хувиар тасарсан байна.

016020432

Аудитын гол асуудал

Бүтцийн өөрчлөлтөөр 27,598.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 6,321.5 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн нь үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурахад нөлөөлжээ.

Бусад асуудлын хэсэг

Орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг мөрдөн шалгах ажиллагаа явуулж санхүүгийн бүх баримт материалыг татан авсан тул аудитад шаардлагатай баримт материалаар хангагдаагүй нь санхүүгийн тайлан дахь дүн мэдээллийг нотлох, аудит хийх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

<i>/ мянган төгрөгөөр/</i>				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		258,375,060.50	591,484,937.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	116,821,414.00	460,046,574.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	33,813,722.80	42,668,741.60
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	2,594,256.60	1,117,227.10
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	51,193,475.30	15,194,476.60
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	468,352.80	346,611.90
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	53,483,839.00	72,111,305.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		629,910,093.30	531,995,705.60
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	434,179.50	434,179.50
37300	Урт хугацаат зээл		434,179.50	434,179.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	629,475,913.90	531,561,526.20
39200	Биет хөрөнгө		568,501,901.60	469,142,944.70
39300	Биет бус хөрөнгө	13	60,974,012.20	62,378,387.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0	40,194.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		888,285,153.80	1,123,480,643.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		222,226,346.00	396,983,373.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	131,558,177.00	288,485,500.50
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	822,145.80	888,901.50
41300	Өглөг	17а, 17б	82,268,556.00	112,959,997.10
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	48,467,475.10	174,636,601.90
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		90,668,169.00	108,497,872.80
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	90,668,169.00	108,497,872.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		666,058,807.80	726,497,269.80
51	Засгийн газрын хувь оролцоо		665,718,238.00	726,156,700.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		154,269,475.10	113,612,544.40
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		5,098,603.50	5,227,965.30
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		888,050.10	1,343,519.90
51200	Хуримтлагдсан үр дүн		477,000,320.50	600,666,445.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		28,461,788.80	5,306,225.30
52	Хяналтын бус хувь оролцоо		340,569.80	340,569.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		888,285,153.80	1,123,480,643.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

<i>/ мянган төгрөгөөр/</i>			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	363,287,487.90	832,988,956.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	136,144,771.70	227,082,075.10
110	Орлогын албан татвар	66,885,829.70	141,172,305.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	67,833,522.20	97,995,778.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-947,692.50	-1,342,557.50
1103	ААН-ын орлогын албан татвар	0	44,519,084.30
113	Хөрөнгийн албан татвар	39,300,876.40	47,602,888.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,958,065.60	38,306,880.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,570,058.60	600,856,154.70
120	Нийтлэг татварын бус орлого	156,724,968.40	581,463,313.80
121	Хөрөнгийн орлого	479,880.00	568,593.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	53,365,210.20	18,824,247.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,572,657.60	5,050,726.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,722,272.80	405,611,754.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,722,272.80	405,611,754.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	155,618,942.70	239,850,038.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,732,946.20	12,683,520.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,421,081.30	1,588,992.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,501,612.00	7,821,065.40
2104	Хангамж, бараа материалын зардал	10,448,165.30	9,012,175.90
2105	Нормативт зардал	7,342,209.40	689,169.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,208,710.70	1,794,098.60
2107	Томилолт, зочны зардал	213,810.20	302,162.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,467,372.20	132,902,263.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,283,035.20	73,056,590.10
212	ТАТААС	31,500.00	340,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,071,830.10	165,421,216.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	124,565,215.10	427,377,202.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	89,271,891.40	306,431,611.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	35,293,323.70	120,945,591.00

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

		<i>/мянган төгрөгөөр/</i>	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	363,287,487.90	832,988,956.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	136,144,771.70	227,082,075.10
110	Орлогын албан татвар	66,885,829.70	141,172,305.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	67,833,522.20	97,995,778.90

1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-947,692.50	-1,342,557.50
1103	ААН-ын орлогын албан татвар	0	44,519,084.30
113	Хөрөнгийн албан татвар	39,300,876.40	47,602,888.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,958,065.60	38,306,880.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,570,058.60	600,856,154.70
120	Нийтлэг татварын бус орлого	156,724,968.40	581,463,313.80
121	Хөрөнгийн орлого	479,880.00	568,593.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	53,365,210.20	18,824,247.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,572,657.60	5,050,726.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,722,272.80	405,611,754.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,722,272.80	405,611,754.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	155,618,942.70	239,850,038.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,732,946.20	12,683,520.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,421,081.30	1,588,992.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,501,612.00	7,821,065.40
2104	Хангамж, бараа материалын зардал	10,448,165.30	9,012,175.90
2105	Нормативт зардал	7,342,209.40	689,169.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,208,710.70	1,794,098.60
2107	Томилот, зочны зардал	213,810.20	302,162.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,467,372.20	132,902,263.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,283,035.20	73,056,590.10
212	ТАТААС	31,500.00	340,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,071,830.10	165,421,216.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	124,565,215.10	427,377,202.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	89,271,891.40	306,431,611.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	35,293,323.70	120,945,591.00

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	657,450,269.80	657,450,269.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,810,703.00	2,810,703.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	660,260,972.80	660,260,972.80
7	Өмчид гарсан өөрчлөлт	-1,317,865.10	-1,317,865.10
8	Зарласан ногдол ашиг	-28,177,623.60	-28,177,623.60
9	Тайлант үеийн үр дүн	35,293,323.70	35,293,323.70
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,058,807.80	666,058,807.80
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	666,058,807.80	666,058,807.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-52,709,389.60	-52,709,389.60

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	613,349,418.20	613,349,418.20
18	Зарласан ногдол ашиг	-7,797,739.40	-7,797,739.40
19	Тайлант үеийн үр дүн	120,945,591.00	120,945,591.00
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	726,497,269.80	726,497,269.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	531,912,206.2	363,521,164.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,327,009.5	248,207,919.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,014,015.1	75,825,195.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,920,305.0	10,351,650.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,561,696.4	1,312,247.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,820,165.7	7,621,403.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,260,711.3	2,128,833.1
2105	Нормативт зардал	99,102.8	96,869.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,794,675.8	1,738,393.0
2107	Томилолт, зочны зардал	276,142.2	219,373.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,577,913.9	15,701,350.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,703,302.0	36,655,074.4
212	ТАТААС	340,500.0	340,500.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	340,500.0	340,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	297,972,494.4	172,042,223.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	296,995,556.6	171,218,445.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	976,937.8	823,778.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,585,196.7	115,313,245.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	531,912,206.2	365,140,264.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,861,449.1	18,824,247.9
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	18,861,449.1	18,824,247.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497,141,999.6	344,557,953.8
320001	Орон нутгийн төсвөөс	497,141,999.6	344,557,953.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,908,757.5	1,758,062.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	7,425,085.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	9,044,184.8

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,556,464.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,583,340.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,194,089.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	82,593.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,220.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,749.1
2104	Хангамж, бараа материалын зардал	235,565.0
2105	Нормативт зардал	46,177.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	324,838.0
2107	Томилолт, зочны зардал	70,557.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	723,246.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,700,141.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,646,277.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,864.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	389,251.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	326,345.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,906.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	973,123.4
2200	Дотоод эх үүсвэрээр	973,123.4
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,528,345.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,528,345.9
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-28,118.1
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,118.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 710.2 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 177.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 383.1 сая төгрөгийн зөрчилд 5 заалт бүхий зөвлөмж, нийцлийн аудиттай холбоотой 127.7 сая төгрөгийн зөрчилд шаардлага, 22.4 сая төгрөгийн зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өглөө.

Албан шаардлага

1. Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 11 иргэнд орон сууц, гэр барихад 78.8 сая төгрөг, 20 оюутны сургалтын төлбөрт 73.2 сая төгрөг, өөр аймгийн цэргийн ангийн тохижилтод 5.0 сая төгрөг, үсчин гоо сайхны анги тохижуулахад 5.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2 "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 6.5 "нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус хяналт тавина", 7.1 "төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" -д заасантай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Телевизийн нэвтрүүлэгт зориулж видео дүрс бичлэгийн камер, дижитал камер худалдан авахад 15.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.2 "урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх"-д заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт: Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Манлай, Сэврэй, Ханбогд, Хүрмэн, Цогт-Овоо сумд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, мөн Баяндалай, Баян-Овоо, Булган, Даланзадгад, Мандал-Овоо, Манлай, Номгон, Хүрмэн сумд Сангийн сайд, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал", 2 дугаар хавсралтаар баталсан "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал"-ын дагуу "Хог хаягдлын үйлчилгээний хураамж"-ийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 "энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутагт үүссэн хог хаягдлыг бохирдуулагч нь төлдөг байх, хураамж нь орон нутагт үүссэн хог хаягдлыг цогцоор нь шийдвэрлэх бодлогод суурилж, иргэн, аж ахуйн нэгжийн гаргаж буй хог хаягдлыг норматив, дээд хязгаарт үндэслэн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг бодитой тогтоон, хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.

1.2.Илрүүлэлт: Малын тоо толгойн орлогын албан татварын 2021-2022 оны ногдлыг 989,758,191 төгрөгийг бүх сум орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1 "Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна", 7 дугаар зүйлийн 7.1 "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг ...өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгээгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө"-д заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах

1.3.Илрүүлэлт: Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 80.5 хувиар тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" -д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар ажил зохион байгуулах

2. Дотоод аудитын холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт: ТЕЗ-н харьяа дүгнэлт гаргасан 80 байгууллагаас санхүүгийн тайланг материаллагаар буруу илэрхийлсэн 21 байгууллагын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", 1 байгууллагын санхүүгийн тайланд "Сөрөг", 2 байгууллагын санхүүгийн тайланд "Татгалзсан" санал дүгнэлт өгсөн.

Энэ нь материаллаг бөгөөд өргөн тархалттай, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байдал, ангилал, эрх ба үүрэг, оршин байх, үнэн зөв байдал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулах

3. Зардалтай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт: Олон нийтийн цагдаагийн цалингийн зардлыг гүйцэтгэлээс 165.1 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" -д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлж байх

3.2.Илрүүлэлт: Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс анхан шатны баримтын бүрдэл дутуу 43.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангуулж ажиллахад анхаарах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн Засаг дарга	7	0.6			2	0.2	5	0.4				
Дүн	7	0.6			2	0.2	5	0.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Аймгийн Засаг дарга	3	0			1	0	2	0	
Дүн	3	0			1	0	2	0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Аймгийн Засаг дарга	3	1.102			1	0.1	2	0.002	
Дүн	3	1.102			1	0.1	2	0.002	
Нийт дүн	13	0.702			4	0.3	9	0.402	

Тав. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	76	24	52		16	8		
2	ОНӨААН	43	39	4		26	11	1	1
3	ОНӨОААН	2	2			1			1
4	ТТЗ	15	15			12	3		
5	ТЕЗ	1	1				1		
	НИЙТ	137	81	56		55	23	1	2